The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

e-journal

AMCHAM CSR

Дугаар 06 | 2022 оны 3-р сар

StarChase
badrakh energy
OBORTECH SMART LOGISTICS HUB
Oyu Tolgoi
ARD
InvesCore
SANDVIK
ХААН БАНК
STEPPE GROUP
pwc
THIESS
Barloworld Mongolia CAT
ГОЛОМТ БАНК
MSM

Steppe Group

Wealthtech x Femtech = Untapped opportunity of Women Economy

Та “хөрөнгө оруулагч ээж” болоход бэлэн үү?

Hello Baby болон ORDA Wealth Tech компаниуд залуу ээж, эмэгтэйчүүдэд санхүүгийн боловсрол олгох, хөрөнгө оруулалт хийж эхлэх санхүүгийн суурь мэдлэгтэй болгох зорилгоор хамтарч ажиллах болсноо зарлалаа. Уг түншлэлийн хүрээнд Hello Baby болон ORDA Wealth Tech нь ээжүүдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх, тэдний аж амьдралыг сайжруулахад тасралтгүй нөлөө үзүүлэх, мөн шинэ үеийн хөрөнгө оруулагч ээжүүдийг бэлтгэхээр эдийн засаг болон хүүхэд асран харах салбар дахь өөрсдийн арвин туршлагаа нэгтгэн ажиллах юм.

ORDA Wealth Tech нь альтернатив хөрөнгө оруулалтын платформ, Стэпп группын гол төсөл бөгөөд жижиг хөрөнгө оруулагчдад тулгарч буй саад бэрхшээлийг хөнгөвчилж, хөгжиж буй болон хөгжингүй зах зээлийг холбосон, үл хөдлөх хөрөнгө, тансаг зэрэглэлийн машин, урлагийн бүтээл, ховор цуглуулга, дижитал хөрөнгө зэрэг олон төрлийн сонирхолтой хөрөнгүүдэд хөрөнгө оруулах боломжийг олгодог. Стэпп групп нь санхүүгийн салбарын үр ашиггүй байдлыг бууруулж, зах зээлд буй баялгийг нийгмийн бүх хэсэгт хүртээмжтэй хуваарилах замаар хөгжиж буй бүс нутгуудад тогтвортой, эрүүл эдийн засгийг бий болгохоор зорин ажиллаж байгаа Монгол Улсад санхүү, технологийн салбарт түүчээлж яваа компаниудын нэгдэл юм. ОРДА төслийн гол санаа нь энгийн хэрнээ маш нөлөө бүхий юм. Хөрөнгө оруулж эхлэхийн тулд халаасандаа ердөө 10-хан доллартай байхад л хангалттай гэвэл та итгэх үү? Санхүүгийн олон төрлийн үйлчилгээг боломжийн үнээр авснаар хүн бүрийн оролцоотой санхүүг бий болгох зорилго биелнэ. Хөрөнгийн хуваагдал буюу хэсэгчилсэн хөрөнгө оруулалт ашиглан альтернатив хөрөнгө оруулалтын багц бүрдүүлж болдог тул ОРДА нь хүн бүрд хүртээмжтэй боломж бий болгодог.

“Хөрөнгө оруулагч ээж” төсөл ээж бүрд хүртээлтэй

“FemTech Solutions” ХХК-ийн санаачлан хөгжүүлсэн эх, хүүхдийн эрүүл мэндийн иж бүрэн аппликейшн Hello Baby нь дижитал бүтээгдэхүүнээр дамжуулан олон нийтийн эрүүл мэндийн боловсрол,



эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэсэн эрүүл мэндийн мэргэжилтнээр баталгаажсан зөвлөгөө мэдээллийг зорилтот бүлэгт энгийн, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэн хүргэх зорилготой ажиллаж байна. Hello Baby нь сар бүр ээжүүдэд зориулсан өөр өөр сэдэвт компанит ажил явуулдаг бөгөөд энэ 3 дугаар сард ORDA Wealth Tech-тэй хамтран “Хөрөнгө оруулагч ээж” төслийг зарлаж байгаа юм. Энэ бол хоёр компанийн үүсгэн байгуулагч эмэгтэйчүүд нь ээжүүдийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхийн тулд хэрхэн нэгдэж буйг харуулж буй гайхалтай түүхийн эхлэл юм.

Хүүхэдтэй болсон цагаас эхлээд эмэгтэй хүний амьдрал бүхэлдээ өөрчлөгддөг. Амьдралын хэв маяг, чухалчилж тавьдаг зүйлсээс эхлээд өөрчлөгддөг. Харин эдгээр зүйлсээс олон эмэгтэйчүүдийн хувьд хамгийн их нөлөө бүхий өөрчлөлт нь санхүүгийн байдал дээр ажиглагддаг. Олон ажлыг зэрэг амжуулж чаддаг, гэр бүлийнхээ арын ажлыг хариуцаж, өрхийн төсөв, санхүүг барьдаг хүмүүс ихэвчлэн ээж нар байдаг. Тийм учраас санхүүгийн цэгцтэй мэдлэгтэй байх нь бүх эмэгтэйчүүдэд, ялангуяа өөрөө ч мэдэлгүй гэрийнхээ санхүүгийн менежер нь болчихсон явдаг бүсгүйчүүдэд маш чухал. Гэр бүл зохиох, тогтвортой мөнгө санхүүтэй байх хоёр хоорондоо байнгын уялдаа холбоотой. Гэсэн хэдий ч эхчүүдэд хувийн санхүүгээ дээшлүүлэх нөөц бололцоо хомсхон байсаар байна.

Та гэрийн сайн ээзгтэйгээс гадна санхүүд “хөлөө олох” нь чухал

Хүн бүр л ижил хоногийн 24 цагтай. Бага насны хүүхэдтэй ээжүүд хүүхдээ хооллох, цэвэрхэн хувцас өмссөн байх гэх мэт энгийн зүйлсийг нэн тэргүүнд тавьдаг боловч өөрсдийнхөө сайн сайхны төлөө, жишээлбэл, ирээдүйнхээ төлөө хэрхэн хөрөнгө оруулалт хийх талаар сурах нь тэдний нэн түрүүнд хийх ёстой зүйлсийн жагсаалтын эхэнд бичигдэхгүй л болов уу. Хөрөнгө оруулалт хийнэ гэдэг нь ээжүүдэд маш төвөгтэй, цаг хугацаа их шаардсан, ойлгоход хүнд сэдэв мэт санагдах нь олонтаа.

Hello Baby болон ORDA Wealth Tech-ийн хоорондын түншлэл нь завгүй амьдралынхаа дундуур санхүүгийн асуудалдаа зориулах багахан цагийг олоход нь ээжүүдэд туслахыг зорьж байна. Хөрөнгө оруулах нь ирээдүйд өгөөжөө өгч, санхүүгийн эрх чөлөөнд хүрэхэд таныг ойртуулна. Санхүү, хөрөнгө оруулалтын үндсэн ойлголтуудыг сурч мэдэх нь энэхүү аяллын нэгээхэн хэсэг.

Эмэгтэйчүүдийн эрх мэдэл, оролцоог нэмэгдүүлэх нь эмэгтэйчүүдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, сонголтоо өөрөө тодорхойлох чадвар, өөртөө болон бусдад нөлөөлөх эрх зэргээр олон янзаар тодорхойлогддог. Гэсэн хэдий ч эдгээрийн аль нь ч эдийн засгийн эрх мэдэлгүйгээр оршин тогтнохгүй. Эдийн засгийн эрх чөлөө нь эмэгтэйчүүдэд нөөц, хөрөнгө, орлогоо хянах, үр шимийг нь хүртэх боломжийг олгодог бөгөөд эрсдлийг удирдах, өөрсдийн сайн сайхан байдлаа дээшлүүлэх, амьдралынхаа сонголтыг төлөвлөгөөтэйгөөр хийх чадварыг нь дэмждэг.

Эмэгтэйчүүд ирээдүйнхээ санхүүгийн төлөө эртнээс санаа тавих хэрэгтэй. Зарим судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүд урт хугацааны зорилгодоо чиглэсэн хөрөнгө оруулалтад илүү анхаардаг, зах зээлийн хүнд хэцүү нөхцөл байдалд илүү сахилга баттай, төрөлжсөн хөрөнгө оруулалтыг сонгох хандлагатай байдаг тул хөрөнгө оруулалт хийхдээ эрэгтэйчүүдээс 1.8 хувиар илүү байдаг.

Та хэрхэн хөрөнгө оруулагч ээж болох вэ?

Санхүүгийн мэдлэгтэй байх нь зөвхөн өөртөө болон үр хүүхдэдээ найдвартай санхүүгийн ирээдүй бий болгох тэдийгүй өр ширэнд орохгүй, санхүүгийн янз бүрийн хууран мэхлэлтэд өртөхгүй байж сурахад тусалдаг. Хөрөнгө оруулалт хийж эхлэхээсээ өмнө ирээдүйн баялгаа бүтээх санхүүгийн найдвартай суурь мэдлэгтэй байх ёстой. ОРДА нь урт хугацаандаа бие биедээ урам зориг өгч, харилцан дэмждэг хөрөнгө оруулагч ээжүүдийн хүчирхэг нийгэмлэгийг бий болгохыг эрмэлзэж байна. Насан туршийн хөрөнгө оруулагчдыг бий болгох цогц төлөвлөгөөнийхөө эхлэл болгон ОРДА Hello Baby-тай хамтран нэг сарын хөрөнгө оруулалтын сургалтын хөтөлбөрийг санал болгож байна. Уг сургалтын хүрээнд ээжүүд санхүүгийн боловсролтой болох, нэмэлт орлогын эх үүсвэрүүдийг судлах, хөрөнгө оруулалтын өөрт таарсан багцыг үүсгэхийн тулд өөрийн санхүүгийн эрсдэл даах чадвараа сонжих боломжтой болно.

Санхүүгийн ерөнхий мэдлэгтэй болж, ямар төрлийн хөрөнгө оруулагч болохоо тодорхойлсны дараа ОРДА-ийн санхүүгийн мэргэжилтнүүдийн зааж буй мастер курст бүртгүүлснээр, өөрийн эрсдэлд тэсвэртэй байдал, цаг хугацааны хүрээ, санхүүгийн зорилгоо хүрч болохуйц, хэмжигдэхүйц зорилт болгон хөрвүүлж, өөрт тохирсон хөрөнгө оруулалтын багцаа бий болгож илүү ихийг мэдэж авах болно. Өөрөөр хэлбэл, та мөнгөө ухаалгаар зарцуулж, санхүүгээ ухаалгаар удирддаг илүү боловсорсон, биеэ даасан эмэгтэй болж чадах юм.

Үүсгэн байгуулагч бид ч бас ээжүүд

Эрүүл мэнд, санхүү, технологи нь ихэвчлэн эрэгтэйчүүд давамгайлсан салбар байдаг боловч Hello Baby болон ОРДА-ийн үүсгэн байгуулагч, удирдагчид нь өөрсдөө ээжүүд. Гэсэн хэдий ч тэд зөвхөн бие биеэ дэмжээд зогсохгүй, технологи, шинэлэг бизнесийн загвар, олон нийтэд хүртээмжтэй байх арга барилаар дамжуулан эдийн засгийн чадавхийг бэхжүүлэхэд хамтран ажилладаг эмэгтэйчүүдийг дэмжихийн тулд хамтын бизнесээ ээжүүд, эмэгтэйчүүд та бүхэндээ зориулж байна. Аж ахуйн нэгжүүд зөвхөн ашгийн төлөө байх ёсгүй. Бизнесийн байгууллагууд нийгмийн хариуцлагатай байх нь нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх хөдөлгөгч хүч юм. Энэхүү утга учиртай түншлэлээр дамжуулан олон эерэг өөрчлөлтүүдийг авчирч чадна гэдэгтээ бид итгэлтэй байгаа бөгөөд цаашид ч энэхүү түншлэлээ урт хугацаанд тогтвортой байлгахыг зорьж байна.

Хэрвээ та Hello Baby & ORDA хамтын ажиллагаа болон “Хөрөнгө оруулагч ээж” төслийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидний сошиал хуудсуудыг шалгахаа мартуузай.

https://www.facebook.com/ordawealth
https://orda.mn/mn/



Ард Санхүүгийн Нэгдэл

Ард Санхүүгийн Нэгдэл нь нийт Монголчууддаа санхүүгийн боловсролыг хүртээмжтэй түгээх Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Орон даяар сургалтаа нээлттэй үргэлжлүүлсээр байгаа ба олон нийтэд санхүүгийн боловсролыг цахимаар түгээх Ард Академи сувгийг үүсгэн байгуулж, үнэ төлбөргүй, чанартай мэдээллээр хангаж ажиллаж байна.

Мөн Ардын Тэтгэврийн Данс компани нь Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны шинэчлэлд хувь нэмрээ оруулж, дуу хоолойгоо идэвхтэй хүргэдэг билээ.

Манай компани нийгмийн хариуцлагын үүднээс, цахим эринд хөл нийлүүлэн алхах үйлсэд түүчээлэх "Digital Nation - 2021" арга хэмжээнд стратегийн түншээр оролцож, олон нийтийг цахим шилжилтэд уриалсан юм.

Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй тамирчид болон тусгай хэрэгцээт боловсролын салбарыг дэмжин ажилласаар ирэв. Улаанбаатар-Сонгдо эмнэлгээс хэрэгжүүлсэн "Зүрх мартахгүй" төслийг дэмжин оролцсон.

Цар тахлын ид дэгдэлтийн үед УОК-т дэмжлэг үзүүлэхээр Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагын Холбооноос санаачилсан хандивын аянд нэгдэж, мөнгөн тусламж үзүүлсэнээс гадна Гадаадад суугаа Монголчууддаа 1 тэрбум төгрөгтэй тэнцэх АрдКойны тусламжийг хуваарилан хүргэсэн билээ. Мөн цар тахлын хамгийн эрсдэлтэй бүсэд ажилласан 100 сувилагчид 100 сая төгрөгийг хуваарилж, тус бүрт 1 сая төгрөг олгов.

Эдийн засаг саармагжсанаас үүдэлтэйгээр төр засгаас хэрэгжүүлсэн ажлын байрыг цөөлөх бус тогтвортой хадгалах бодлогыг дэмжин хэрэгжүүлж, цар тахлын үед 121 ажлын байрыг бий болгов.

Үндэсний хэмжээнд ТЭРБУМ МОД тарих хөдөлгөөнийг дэмжин ажиллаж, Сонгинохайрхан дүүргийн Бумбатын булагт Ардын нэрэмжит төгөлтэй болсон нь бидний хувьд нэн таатай үйл явдал байв.

Өнгөрсөн онд болсон үйл явдлын нэг нь Монгол улсын өнцөг булан бүрд буюу 21 аймаг, 330 сумдад санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй түгээх, зорилгоор Илгээлтийн Эзэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутагтаа амарч буй оюутан залуусыг цалинтай дадлага хийлгэсэн нь тэдний хувьд томоохон туршлага болсон юм.



Хүчтэй. Хамтдаа.

Хүчтэй. Хамтдаа.

Хүчтэй. Хамтдаа

Хүчтэй. Хамтдаа

Бид холбоо харилцаагаа улам өргөжүүлж, Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банкнаас уламжлал болгон зохион байгуулдаг хамгийн том арга хэмжээ болох Санхүүг эмэгтэйчүүдийн төлөө ажиллуулах арга хэмжээний спонсороор ажилласан нь олон эмэгтэйчүүдэд итгэл өгсөн үйл явдал байлаа.

Нийгмийн сайн сайхны төлөөх ажлаа идэвхжүүлж, илүү далайцтай болгох үүднээс санхүүгийн боловсрол, шинэ технологи инноваци, ногоон хөгжил, байгаль орчин, хүүхэд, урлаг, спортын чиглэлийн төсөл санаачилгуудыг дэмжин ажиллах XACY буюу Хүчирхэг Ардын Сайн Үйлс ТББ, Монголын хамгийн том ТББ-ыг үүсгэн байгуулаад байна.

Санхүүгийн үйлчилгээг зөвхөн насанд хүрэгчдэд хүргэх нь явцуу тул хүүхэд багаасаа санхүүгийн харилцаанд зөв зохистой оролцоход сургах зорилготой, хүүхдийн санхүүгийн хэрэгцээг хангасан хамгийн анхны цогц аппликэйшн болох ArdKids Аппыг танилцуулав.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд болох Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих, Тэгш бус байдлыг бууруулахыг дэмжиж, "NO ONE LEFT BEHIND. TOGETHER. Буюу ХЭН Ч ХОЦРОХ ЁСГҮЙ. ХАМТДАА." төслийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санхүү, хөрөнгийн зах зээлийн сургалтад хамруулах ажлаа мөн эхлүүлээд байна.

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоохын зэрэгцээ хүүхэд бүрийн ирээдүй гэрэлтэй байхыг билэгдэж, эх орны ирээдүй болсон хүүхэд багачууддаа криптовалютаар өв хөрөнгө бий болгож өгөх, ирээдүйд тэдний амьдралын эхлэл, санхүүгийн баталгаа болох үүднээс Монгол Улсын иргэн, 0-18 насны хүүхэд бүрд 77-100 АрдКойны хадгаламж үүсгэж өгөв.

Санхүүгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, мэргэжлийн карьераа эхлүүлэх боломжийг олгох, оюутан залуусын идэвх оролцоог дэмжих зорилготой Ard Students Challenge хөтөлбөрийг зарлаж, оюутан залуусыг дэмжин ажиллаж эхэллээ.

“Бадрах Энержи” ХХК хүүхэд, залуучуудын боловсролд хөрөнгө оруулж байна

“Бадрах Энержи” ХХК хүүхэд залуусын сурч боловсрох нөхцөлийг сайжруулан боловсролын салбарт хөрөнгө оруулсаар ирсэн билээ. Хамгийн сүүлийн жишээ болж компаниас Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын ширээ, сандал шинэчлэх төслийн хүрээнд нийт 25 сая төгрөгийн үнэ бүхий 80 ширээ, 160 сандал зэргийг 2021 оны 10 дугаар сарын 14-нд хүлээлгэн өглөө. Төслийн үр дүнд тус сургуулийн 5 ангийн ширээ, сандал бүрэн шинэчлэгдэж хүүхдүүдийн сурах орчин, тав тухтай байхад ихээхэн хувь нэмэр орууллаа.

Хүүхэд залуусын сурч боловсрох нөхцөлийг сайжруулан боловсролын салбарт “Бадрах Энержи” ХХК-иас Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн ЕБС-д хүүхдийн автобус хүлээлгэн өгсөн явдал юм.

“Бадрах Энержи” ХХК-д Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн ЕБС-ийн зүгээс сурагчдын олимпиад, уралдаан тэмцээнд оролцох, орон нутагтай танилцах болон мэргэжлийн чиг баримжаа олгох, сургалт семинарт оролцох зэрэг аялал зохион байгуулахад ашиглах сургуулийн хүүхдийн автобустай болох хүсэлт ирүүлсэн билээ. Хүсэлтийн дагуу компанийн зүгээс “Hyndai Starex H1” маркын 12 хүний суудалтай автобус худалдан авч, өнгөрөгч 12 дугаар сарын 22-ны өдөр ЕБС-ийн удирдлагад хүлээлгэн өглөө.

Picture 1-2: The new desks and chairs in classrooms

Зүүнбаян багийн ЕБС-ийн захирал Х.Отгонбаяр: “ Хүүхдийн төлөө чинхүү сэтгэл гарган хамтран ажилладаг “Бадрах Энержи” ХХК-ийн хандивласан хүүхдийн автобусаа хүлээн авлаа. Хүүхдүүд маань өвлийн хүйтэн, зуны халуунд ажрахгүй төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцох боломжтой боллоо. Сэтгэлтэй, зүтгэлтэй та бүхнийг хүүхдийн цагаан буян ивээж явах болтугай! Маш их баярлалаа!”, хэмээн багш, сурагчдынхаа өмнөөс компанийн хамт олонд талархлаа илэрхийлэв.

Зураг 1: “Бадрах Энержи” ХХК-ийн нийлүүлсэн сургуулийн хүүхдийн автобус
Зураг2: Зүүнбаян багийн ЕБС-ийн захирал Х.Отгонбаяр, компанийн Орон нутгийн харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Буянхишиг нар хүүхдийн автобус гардуулан өгөх үеэр

Badrakh Energy LLC is pleased to invest in the educational sector and support the learning of children and youth.

Badrakh Energy LLC

FXB Дорноговь орон нутгийн төсөл хоёр дахь удаагийн гурван жилийн төслөө амжилттай хэрэгжүүлж дуусла

Орано Сан (хуучнаар AREVA Сан), Монгол Улс дахь “Бадрах Энержи” ХХК--иар дамжуулан François-Xavier Bagnoud (FXB) нийгэмлэгийн тусламжтайгаар Дорноговь аймагт иргэдийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд нь сургах чиглэлээр хоёр удаагийн хөтөлбөрөө 2016 -2018 болон 2019-2021 онд тус тус хэрэгжүүллээ.

2019-2021 онд хэрэгжсэн орон нутгийн 2 дахь хөтөлбөрийн хаалтын арга хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 23-нд зохион байгуулж, үр шим хүртэгчдийн бүтээлээр үзэсгэлэн гаргав.

Зураг 1-2: Хаалтын арга хэмжээ, түүгээр гаргасан үр шим хүртэгчдийн бүтээлийн үзэсгэлэн

Хаалтын арга хэмжээнд оролцож сэтгэгдлээ хуваалцсан үр шим хүртэгчид хөтөлбөрөөс зохион байгуулсан уулзалт, сургалт, арга хэмжээний ач холбогдол, өгөөжийг онцлохын зэрэгцээ хадгаламжтай байхын үр ашиг, өрхийн санхүүгээ хэрхэн зөв зохицуулах гээд ахуйн болон амьдрах ухаан, сэтгэлзүйн тал дээр нилээд их мэдлэг, мэдээлэл, туршлага хуримтлуулж, амьдралдаа хэрэгжүүлэн, амьдралын хэв маягаа өөрчлөөд эхэлсэн тухайгаа хуваалцав.

Энэхүү арга хэмжээний хүрээнд FXB Дорноговь төслийн хамт олон Улаанбадрах сум, Зүүнбаян багийн үр шим хүртэгчидтэй орон нутагт нь очиж уулзсан ба уулзалтанд Улаанбадрах сумын засаг дарга Г.Ганбүрэн, Зүүнбаян багийн засаг дарга Ч.Бадамлянхуа нар оролцлоо.

Зураг 3-4: Төслийн багийнхан Улаанбадрах сум, Зүүнбаян багт очиж ажиллав

Ийнхүү Дорноговь аймгийн ард иргэдэд үр шимээ өгсөн FXB Дорноговь төсөл 2016- 2021 онд амжилттай хэрэгжиж, уг төслөөр дамжуулан төсөлд хамрагдсан иргэдийн амьжиргаа, орлогын эх үүсвэр сайжирч, эрүүл мэнд, сурч боловсрох хүсэл тэмүүлэлд нь хувь нэмрээ оруулсандаа Орано группийн Уул уурхайн салбарын хамт олон, тухайлбал “Бадрах Энержи” ХХК-ийн хамт олон маш их баяртай байна.

Barloworld Mongolia LLC

“Барловорлд Монголиа” ХХК

“Барловорлд Монголиа” ХХК-аас санаачлан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Харилцагчдын дундах Гольфийн тэмцээний хандивыг НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН хүрээнд төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлж ирснээр даруй 8 ЖИЛ өнгөрчээ.

Гэрээсээ зайтай сургуулийн дотуур байранд амьдардаг сурагчдад гэртээ мэт ая тухыг бүрдүүлж, сурч хөгжихөд нэн чухал хэрэгцээ юу байдаг бол? Ийм л асуултын хүрээнд бид 2021 онд Өмнөговь аймгийн алслагдсан сум болох Гурвантэс сумын дунд сургуулийн сурагчдын дотуур байрыг сонгон авч Нийгмийн хариуцлагынхаа төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 3 чиглэлд туслалцаа үзүүлээ.

Нэгдүгээрт: Сурагчдын цахим хичээл, сургалтын бааз суурийг бэхжүүлэх чиглэлд сургалтын өрөөнд сурагч ширээ 15ш, сандал 30ш, суурин компьютер 4ш, 55инчийн ухаалаг телевиз 1ш зэргээр тоноглолоо.

Хоёрдугаарт: Сурагчдын тав тухтай орчинд, чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх чиглэлд дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөөнд засвар хийж, номын сан байгуулж өгөв. Тус номын санг уран зохиол, хувь хүний хөгжил, бизнес санхүү, цаашлаад хэрхэн олон улсын их дээд сургуулиудад амжилттай элсэн суралцах вэ? зэрэг агуулгатай 120 гаран номнуудаар баяжуулсан ба эдгээр номнуудын тодорхой хувийг Барловорлд Монголиа ХХК-ийн ажилчид сайн дурааараа хандивлаж оролцсон юм.

Гуравдугаарт: Анхдагч хэрэгцээ, ариун цэвэр, аюулгүй байдлын чиглэлд дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн хувцас, хэрэглэлээ угаах хагас автомат угаалгын машин 4 ширхэгийг суурилуулж өглөө.

Хүүхэд залуучууд амьдарч байгаа газраасаа үл шалтгаалан тав тухтай амьдарч, сурч хөгжих боломжоор ижил, бүрэн хангагдаж байгаасай.

Golomt Bank

Зүрх мартахгүй төсөл

Голомт банкны дэргэдэх “Алтантүлхүүр” хүүхдийн сан “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн “Зүрх мартахгүй” төслийн албан ёсны хамтрагчаар ажиллах санамж бичгийг байгуулж, хоёр дахь жилдээ дэмжин ажиллалаа. Уг төслийн хүрээнд 2020 оны байдлаар 170 бяцхан хүүхдэд зүрхний мэс засал хийж, амьдрал бэлэглээд байна. “Зүрх мартахгүй” төслийг санаачлан хэрэгжүүлэгч “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн хамт олон улирал бүр алслагдсан аймаг, сумдад очиж үнэ төлбөргүй үзлэг хийх, 2027 он гэхэд нийт 1,000 хүүхдэд зүрхний мэс засал хийх зорилтыг тавин ажиллаж байна.

Бяцхан зүрхэнд амьдрал бэлэглэе!

Голомт банк хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш сурах боломжоор хангав

Сайн сайхныг санхүүжүүлэгч Голомт банкны хамт олноос хүүхдийн эрхийг хамгаалж, сурах тэгш боломжоор хангах сайн үйлсийн хүрээнд нийслэлийн тусгай хэрэгцээт боловсролын 25 дугаар сургуулийн Мэдээлэл, технологийн танхимыг бүрэн засварлаж, ухаалаг самбар, проектор болон компьютерын тоног төхөөрөмж хандивлалаа. Мөн хараагүй хүмүүсийн эрхийг хамгаалах “Дэлхийн цагаан таягтны өдөр”-өөр харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн 116 дугаар сургуулийн сурагчдад бусдын тусламжгүйгээр интернэт орчинд суралцах, хөгжих боломжийг нь бүрдүүлж, монгол хэлтэй, цахим брайл төхөөрөмж хандивласан билээ.



100 оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Боловсролыг тууштай дэмжигч, сайн сайхныг санхүүжүүлэгч Голомт банкнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Голомт Банкны Нэрэмжит Оюутны Тэтгэлэгт Хөтөлбөр"-ийн шилдэг оюутнуудыг тодруулан зарлалаа. Голомт банкны нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрт Монгол Улсын их, дээд сургуулиудын төгсөх курсийн оюутнууд мэргэжил харгалзахгүй хамрагдах боломжтой бөгөөд өргөн цар хүрээнд зохион байгуулагддагаараа давуу талтай билээ. Хөтөлбөрт шалгарсан оюутнууд бүтэн жилийн турш тэтгэлэг аваад зогсохгүй мэргэжлийн болон хувь хүний ур чадвар хөгжүүлэх сургалт, олон нийтийн арга хэмжээнд хамрагдах, банкны судлаач оюутны багт дадлага хийх, цаашлаад ажлын гараагаа банкнаас эхлүүлж, өсөн дэвжих зэрэг ихээхэн ач холбогдолтой. Бизнесийн байгууллагууд дундаас анхлан санаачлан хэрэгжүүлсэн тус хөтөлбөрийн хүрээнд Голомт банк 2003 оноос эхлэн өнөөдрийг хүртэл нийт 1,500 оюутанд нэг тэрбум гаруй төгрөгийн тэтгэлэг олгосноор тэдний сурч хөгжих, чанартай боловсрол эзэмших хүсэл эрмэлзлийг нь бодитоор дэмжин, оюуны хөрөнгө оруулалт хийгээд байна.
Ирээдүйг бүтээх их үйлсийн эзэд...

Инвескор ББСБ ХК

Инвескор ББСБ ХК нь 2020 оноос хойш Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих цогц хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хөтөлбөрт хамрагдсан бизнес эрхлэгчид зөвхөн санхүүжилт авахаас гадна өөрсдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн болон бизнес зөвлөх үйлчилгээ, тусгайлсан сургалтуудыг авах боломжтойгоороо давуу талтай.
Тус хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 8 сард Инвескор ББСБ ХК нь Рио Тинто Монгол компанитай хамтран Ковид цар тахлын нөлөөлөл өртсөн үндэсний үйлдвэр эрхлэгчид болон бичил бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдгээрийн ажлын байрыг хадгалахад чиглэсэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий санхүүжилтийг олгож эхэлсэн.
Энэ хугацаанд 20 гаруй төрлийн үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн 63 бизнес эрхлэгчдэд 1,410,500,000 төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож үндэсний үйлдвэрлэгчдийн бизнесийг бодитоор дэмжин ажиллалаа. Манай хөтөлбөрт хамрагдан санхүүжилт авснаар 500 орчим хүний амьдралд эерэг нөлөө үзүүлэн, 260 гаран ажлын байрыг хадгалж, 20 орчим ажлын байрыг шинээр үүсгэсэн бөгөөд 38 импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, 28 эмэгтэй бизнес эрхлэгч, 8 байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, 6 хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч, болон 3 өрх толгойлсон эцэг, эхийн бизнесийг тус тус дэмжин ажиллалаа. Бизнесийн чиглэлээр авч үзвэл 85% нь үндэсний үйлдвэрлэл эрхлэгч байсан бөгөөд үлдсэн хувийг үйлчилгээ эрхлэгчид эзэлж байгаа бөгөөд оёдол, оёдлын чиглэлийн үйлдвэр эрхлэгчид, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч, хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч, гар урлал, тавилга, модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгч нарын бизнес нь өндөр хувиудыг эзэлж байна.
Хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх (BEST) хөтөлбөртэй хамтран сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа, жижиг, дунд бизнес эрхлэгчид өөрсдөө бизнесийн шинэ төслөө танилцуулах, хоорондоо дадлага, туршлагаа хуваалцах зэрэг сургалт хөгжлийн үйл ажиллагааг шат дараатайгаар зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2022 оны эхнээс хөтөлбөрт хамрагдсан нийт жижиг, дунд бизнес эрхлэгчид нартаа зориулсан 2 сарын хугацаатай "Бизнесийг дэмжих хурдасгуур хөтөлбөрт хамруулахаар төлөвлөөд байна.
Мөн Инвескор санхүүгийн групп нь хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв" НӨҮГ-тэй хамтран ажиллаж Улаанбаатар хотын 9 дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд танилцуулах сургалт, зөвлөгөөг зохион байгуулж тэдгээр харилцагч нарт хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлийн бүтээгдэхүүнээ санал болгон ажиллаж байна.

Энэхүү хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтөөрөө санхүүжигдэн үргэлжлэх юм.







ХААН Банк “Эмэгтэйчүүдийг дэмжих хөгжлийн хөтөлбөр”-өө зарлалаа

ХААН Банкны нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч ХААН Банк Сангаас эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, тэдний хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжих, мөн албан тушаал, ажил үүрэг, мэргэжлийн онцлог, давуу талыг нийгэмд таниулах, эерэг хандлага бий болгох зорилготой “Эмэгтэйчүүдийг дэмжих хөгжлийн хөтөлбөр”-ийг 2 дахь жилдээ хэрэгжүүлэхээр боллоо.

Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, тэдний хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжих, мөн албан тушаал, ажил үүрэг, мэргэжлийн онцлог, давуу талыг нийгэмд таниулах, эерэг хандлага бий болгох зорилготой тус хөтөлбөр эхний жил амжилттай хэрэгжсэн.

Тус хөтөлбөрт энх тайван, эрүүл оршин байхын төлөө эрүүл мэндийн салбарт зогсолтгүй хөдөлмөрлөж буй сувилагч, асрагчид хамрагдах юм.

Хөтөлбөрт шалгарсан оролцогчид хувь хүний хөгжил, англи хэл, санхүүгийн боловсрол болон сэтгэлзүйн сургалтаас сонгон суралцах бөгөөд идэвх оролцоо, сурлагын үзүүлэлтээрээ манлайлсан оролцогчид дотоодын их, дээд сургуулийн мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдах сургалтын төлбөрийн 90 хувийн тэтгэлэг авна. Хөтөлөрийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг www.khanbank.com болон ХААН Банкны сошиал сувгуудаар авах боломжтой.

Өдгөө ХААН Банк сан үүсгэн байгуулагдсанаасаа хойш нийт 480 орчим төсөл хөтөлбөрийг 7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлээд байна.

MSM Групп ХХК нь Автомотив, Индастриал, Шингэн хүнс гэсэн бизнесийн үндсэн 3 салбарт үйл ажиллагаа явуулахаас гадна компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, хүүхдийн боловсрол зэрэг олон чиглэлээр нийгмийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг юм. MSM Групп ХХК-ийн 2021 онд хэрэгжүүлсэн дараах нийгмийн хариуцлагын төслүүдийг танилцуулж байна.

MSM Групп ХХК-аас “Амгалан” амаржих газар, “Хүрээ” амаржих газарт зөөврийн эхо аппарат, нярайн амьсгалын аппарат хандивлалаа:

MSM Групп ХХК-аас компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Нийслэлийн III-р төрөх эмнэлэг буюу “Амгалан” амаржих газарт зөөврийн эхо аппарат, II-р төрөх эмнэлэг буюу “Хүрээ” амаржих газарт нярайн амьсгалын аппаратыг тус бүр хандивлалаа. Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлын энэ үед эрсдэлд өртөх өндөр магадлалтай эх, нярайн эрүүл мэндийг хангаж ажиллах нь эрүүл мэндийн салбарынханд нэн тулгамдаж буй асуудлуудын нэг юм. Тодруулбал, жирэмсэн эмэгтэйчүүд Ковид-19 халдварын улмаас дутуу төрөх, халдварын өвчлөл нь хүндрэх, эх хүүхдийн эндэгдэл гарах зэрэг ноцтой хүндрэлүүд гарч байгаа юм. MSM Групп ХХК-аас эдгээр эрсдэлүүдийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулж, эх нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор “Амгалан” амаржих газар болон “Хүрээ” амаржих газруудыг тус тус сонгон нэн шаардлагатай буй эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг хандивласан юм.

MSM Групп ХХК Shambala2056 төслийн “BE HUMAN” буюу “Байгальд Хайртай Хүн Бай” аянд нэгдлээ:

MSM Групп нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Shambala2056 төсөл болон Лантуун ДОХИО ТББ-ын хамтран хийж буй “Байгальд Хайртай Хүн Бай” аянд нэгдэн хөрсний доройтол, цөлжилтөд өртсөн орон нутгийн бүс нутаг болох Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт тарьж ургуулж буй ой модод 286 мод тарьж, мөн Улаанбаатар хотын захын байршил буюу Улиастайн эцэст 286 мод тарьсан буюу нийт 572 модыг тарьж ургуулан, мөн модны 5 жилийн арчилгаа, тордолтыг дэмжин ажиллаж байгаа юм.

MSM Групп ХХК Дүдү Боловсролын сангийн “ДҮДҮ МАШИН” хөтөлбөртэй хамтран ажиллалаа:

MSM Групп ХХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхэд багачуудын STEAM боловсролыг (Science, Technology, Engineering, the Arts and Mathematics - Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, урлаг, математик) дэмжих, эдгээр сургалт хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр Дүдү Боловсролын сангийн “ДҮДҮ МАШИН” хөтөлбөртэй хамтран ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд гар урлалын багаж хэрэгслүүдийг ашиглан “Дүдү машин” өөрөө бүтээх тухай цуврал заавар ном хэвлэгдэж, хүүхэд багачуудад физикийн үндсэн ойлголт мэдлэгийг өгөн, машин бүтээх аялалд замчлан дагуулж байна

MSM Групп ХХК “Ургамалын далай” ХХК-д мод тарих тоног төхөөрөмжийг хандивлалаа:

MSM Групп ХХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд цөлжилт, агаар орчны бохирдол зэрэг нэн тулгамдаад буй байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх, шийдлийг бодитоор хэрэгжүүлж, олон нийтийг уриалан ажиллаж байгаа байгууллагуудын нэг болох “Хашаандаа сайхан амьдаръя” төслийн санаачлагч, гадна орчны тохижилт, ногоон байгууламжийн “Ургамалын далай” ХХК-д мод тарих, ногоон байгууламжийн тохижилтын бүхий л ажилд ашиглах Bobcat брэндийн бага оврын ачигчийн газар ухагч нэмэлт хошууг хандивлан, дэмжин ажиллалаа.

MSM Групп ХХК Мишээл Хүүхдийн Санг дэмжин хамтран ажиллалаа:

MSM Групп ХХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Мишээл Хүүхдийн Сантай хамтран ажиллалаа. Мишээл Хүүхдийн Сан нь шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжгүй хөдөө орон нутгийн иргэдэд болон Улаанбаатар хотын амьдралын түвшин доогуур иргэдийн хүүхдүүдэд үнэ төлбөргүй эмчилгээ,үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллага юм. Мишээл Хүүхдийн Сан нь Завхан аймгийн Яруу, Шилүүстэй, Идэр сумын 760 гаруй хүүхдэд үнэ төлбөргүй амны хөндийн эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн юм. Монгол улсын баруун хязгаар руу аялсан энэ хөтөлбөрийг MSM Групп ХХК нь Mercedes-Benz автомашинаар ханган, хөдөө орон нутгийн хүүхдүүдэд нэн шаардлагатай амны хөндийн эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд хувь нэмрээ оруулж хамтран ажиллалаа.

OBORTECH: Дэлхийн ханган нийлүүлэлтийн сүлжээний ирээдүйн төлөв

Цар тахал гарснаас хойш хоёр жил болж байгаа энэ хугацаанд технологийн компаниуд дэлхий даяар тулгарч буй нийлүүлэлтийн сүлжээний олон триллион долларын асуудлуудыг шийдвэрлэхээр зорьж ажиллаж байна.

Дэлхийн эдийн засгийн форумын мэдээлснээр, олон улсын тээврийн зардлын 20% нь бичиг цаасны ажилд зарцуулагддаг нь одоогийн нийлүүлэлтийн сүлжээний үйл ажиллагааны аргууд нь өртөг өндөртэй, цаг хугацаа их шаарддаг, хуучирсан гэдгийг харуулж байна. Бизнесүүд ил тод байдал, ашгийн хувьд сул талтай тулгарсаар байна.

Энэ асуудлыг шийдэхийн тулд Obortech блокчейн технологид суурилсан бизнесийн харилцааны цахим экосистем болох Smart Hub-ыг нэвтрүүлж байгаа нь компаниудад нийлүүлэлтийн сүлжээн дэх ил тод байдлыг хадгалах, үүнийгээ дотоод болон гадаад орчинд дамжуулах боломжийг олгож байна. Obortech-ийн түншүүд болон бодит амьдрал дээр батлагдсан use case-үүд (www.obortech.io) ханган нийлүүлэлтийн сүлжээгээр зогсохгүй Ази, Европ дахь бизнесийн олон хүрээг хамарч байна.

Хүн бүрт зориулагдсан энгийн цахим экосистем

Obortech-ийн хэрэглэгчид Facebook (Meta)-тэй төстэй энгийн интерфейсээр дамжуулан бизнесийн үйл ажиллагаагаа явуулах, хянах боломжтой. Уламжлалт системүүдтэй харьцуулбал Obortech-ийн Smart Hub экосистем нь хэрэглэгч байгууллагуудын хэмжээ, технологийн боломж чадамжаас үл хамааран төвлөрсөн бус, ардчилсан блокчейн сүлжээнд алсаас хамтран ажиллахад нь туслах зорилготой юм.

Smart Hub экосистемийн санал болгодог шинэ боломжууд:

- Блокчейн ба үүлэн технологид суурилсан мэдээллийн харилцаа
- Баталгаат орчинд бичиг баримтыг цахимаар солилцох
- IoT мэдрэгчүүдээр үйл ажиллагаагаа шууд хянах
- Бизнесийн цахим харилцааны шинэ орчин үүсгэх

Obortech-ийн онцлох үйл явдлууд:
Веб хуудас: Obortech.io

- Microsoft компаниас зарласан олон улсын Зууны хөтөлбөрийн 500 төслийн шилдэг 6-н нэгээр шалгарсан; улмаар Microsoft-ын Startups Founders Hub-ын гишүүн болсон
- Олон Улсын Худалдааны Зөвлөлийн (International Trade Council) итгэмжлэгдсэн гишүүн болсон
- №1 Remote Accelerator болох Newchip компанийн Seed & Series-A хөтөлбөрт дэлхийн 1400 гаруй өргөдлөөс 9.6% нь сонгогдсоны нэг болсон
- Дэлхийн хамгийн том далайн тээврийн компанийн технологийн хамтрагч Дани Улсын Onomondo компанитай хамтран ажиллаж эхэлсэн
- Logistics Tech Outlook сэтгүүлийн “2021 оны шилдэг компани” болсон

Төвлөрсөн бус, ардчилсан экосистем

Smart Hub нь төвлөрсөн бус зарчмаар ажиллах бөгөөд хэрэглэгч төвтэй юм. Хэрэглэгч байгууллагуудын тухайн бизнесийн орчиндоо тааруулан өөрсдөө блокчейн сүлжээгээ үүсгэх, түүнийгээ удирдан зохион байгуулахаар загварчлагдсан. Үүсгэсэн сүлжээндээ тухайн байгууллага нь хамтрагч байгууллагуудаа урьж, шинээр элсэж буй гишүүний оролцох эрхийг өмнөх гишүүд нь баталгаажуулдаг. Ингэснээр үл таних гаднын этгээд сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх, мэдээлэл гадагшаа алдагдах, худал мэдээлэл оруулсан этгээд хариуцлагаас зайлсхийх зэргээс сэргийлнэ.

Бодит амьдрал дээрх бодит асуудлуудыг шийдвэрлэх нь

Цар тахлын нөхцөл байдлын улмаас биеэр уулзан ажиллах нь хязгаарлагдмал болсон билээ. Цаасан дээр суурилсан болон гар аргаар мэдээлэл цуглуулах нь удаан бөгөөд зардал ихтэй байдаг. Одоогоор Obortech нь энэ үйл ажиллагааны хэвшмэл байдлыг блокчэйн технологи ашиглан “дижитал” шийдлээр хялбарчлах зорилготойгоор Монгол дахь олон экспортлогч болон зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

OBORTECH

Comparative Matrix

	Current legacy systems	Obortech
Cost	• Pay for heavy upfront investment and full-time in-house tech team for maintenance.	• Pay-as-you-go. • No need for maintenance.
Tracking and monitoring	• Track only location and sealing of consignment several times at specific points throughout the shipment.	• Track and monitor location, sealing, temperature, humidity, and shock of consignment in real-time.
Access to data	• Access data from designated locations via on-premise local system.	• Access data from anywhere and anytime via cloud-based web and mobile applications, and APIs.
Information flow	• Scattered among multiple sources and inconsistent formats.	• Organized on unified source with consistent formats.
Data management	• Paper based and manually stored.	• Digital and tamper-proof on decentralized blockchain network.
Data usability	• Incapable for automation and efficient analytics.	• Open to Smart contract and Big data analytics.
Governance	• Centralized	• Decentralized

Oyu Tolgoi LLC

Өсвөр насныхан эрүүл мэндийн хувьд харьцангуй эрүүл чийрэг бүлэгт хамаардаг ч тэдний нөхөн үржихүй, сэтгэл зүйн эрүүл мэнд нийгмийн тулгамдсан асуудал хэвээр байна. ЕБС-ийн сурагчдын дунд БЗХӨ, насанд хүрээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн тоон үзүүлэлт өндөр байгаа бөгөөд олон тохиолдлыг холбогдох байгууллагууд мэдэхгүй өнгөрч, бүртгэхэд ч амаргүй байдалтай байна. Мөн стресс бухимдалд өртөх, өөртөө итгэлгүй болох цаашлаад амиа хорлох зэрэг сэтгэл зүйн асуудалтай хүүхдүүд нүүр тулж, хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй дотроо шаналж явна. Судалгаагаар 4 сурагч тутмын нэг нь сэтгэл зовинолтой гэж гарчээ. Цар тахлаас үүдэлтэй хөл хорио нөхцөл байдлыг улам дордуулж байгаа ба өсвөр насны хүүхдүүдэд тулгамдаж байгаа сэтгэл зүйн асуудлууд нь насан туршийн амьдралд нь сөргөөр нөлөөлөх тохиолдлууд цөөнгүй байдгийг мэргэжилтнүүд сануулж байна.

9. Оюу толгой ХХК

Оюу толгой ХХК компаниас нийгмийн эрүүл мэндийн энэхүү асуудалд анхаарлаа хандуулж, нийгмийн хариуцлагын хоёр дах гол чиглэл болгон сонгож, гэр хорооллын ЕБС-д зориулан "Эрүүл мэндийн төсөл"-ийг 2020 оноос хэрэгжүүлж эхэлжээ. Төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн гэр хороололд байрлах таван ЕБС-ыг сонгон авч сурагч, багш нар, сургуулийн удирдлага, эцэг эхчүүдэд нөхөн үржихүй, сэтгэл зүйн эрүүл мэндийн цогц сургалтуудыг зохион байгуулж, сургуулиудад үе тэнгийн зөвлөх бэлтгэн, байнгын үйл ажиллагаатай эрүүл мэндийн клуб бий болгохын зэрэгцээ сургуулиудад сэтгэлзүйч ажиллуулан, зөвлөгөө тусламж нэн шаардлагатай байгаа сурагчдад мэргэжлийн зөвлөгөө өгсөн байна. Сургалтаас гадна хүүхдэд ээлтэй, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн сургалтын жишиг кабинетуудыг сонгогдсон сургууль бүрт байгуулж өгчээ. 2020-2021 оны хичээлийн жилд танхим, онлайн хосолсон хэлбэрээр 10 мянга гаран хүн төслийн үр өгөөжийн хүртжээ. Төслийн үр дүнд үндэслэж, БШУЯ-нд ЕБС-д сэтгэл зүйч ажиллуулахын ач холбогдол, гарах үр дүнгийн талаар саналаа хүргүүлсэн байна.

2021-2022 оны хичээлийн жилд төслийн II үе шат мөн Сонгинохайрхан дүүргийн гэр хороллын ЕБС-ийн дөрвөн сургуульд хэрэгжиж байгаа аж. Төслийн хүрээнд цогц сургалтууд явагдаж, сэтгэл зүйчид ажиллах ба сэтгэл зүйн кабинетийг мөн адил байгуулах юм. Сэтгэл зүйн тандалт оношлогоогоор санал болгосон 15 сурагчийг Жию жицу тулааны спортоор хичээллэх боломжоор хангах ажээ.

Таван сургуульд хийгдсэн судалгааны үр дүнгээс:

Сэтгэл судлаачдын илрүүлсэн нийтлэг асуудлууд:

- 10 хүүхэд тутмын 8 нь дэлгэцийн хэт хэрэглээтэй буюу хамааралтай болсон байж болзошгүй,
- 10 хүүхэд тутмын 7 нь дасгал хөдөлгөөн хийдэггүй,
- 10 хүүхэд тутмын 5 нь эрүүл бус хооллолтын дэглэмтэй,
- 10 хүүхэд тутмын 5 нь нойрны асуудалтай болсон байж болзошгүй шинж тэмдгүүд ажиглагдаж байна.

#Эрүүл ирээдүй Монголын ирээдүй.

Porsche Center Ulaanbaatar

Porsche Улаанбаатар төв Бундан сангийн "Зүрх Мартахгүй" төсөлд зориулж хандивийн арга хэмжээ зохион байгууллаа.

Монгол улсад 1000 хүүхэд тутмын 1 нь төрөлхийн зүрхний гажигтай төрдөг бөгөөд үүнээс 20-30% хувь нь зүрхний мэс засалд орох шаардлагатай байдаг байна. Гэвч гэр бүлийн санхүүгийн чадамжгүй байдлаас шалтгаалан тэдгээр хүүхдүүдийн дийлэнх нь мэс засалд орох боломж дутмаг байдаг. 2018 оноос эхлэн Зүрх, судасны мэс засалч Б.Болдсайхан эмч нь "Бундан сангийн" Зүрх Мартахгүй төслийн хүрээнд хөдөө орон нутаг тэр дундаа алслагдсан аймаг, сумдуудруу очиж 800 гаруй зүрхний гажигтай хүүхдүүдийг үнэ төлбөргүй оншилж, 200 гаруй хүүхдэд үнэ төлбөргүй зүрхний мэс засал хийжээ. "Старчейз Групп Монгол" компанийн нэг хэсэг болох Porsche Улаанбаатар төв нь нь жил бүр зохион байгуулдаг "Porsche Эзэмшигчдийн Үдэш" 2021 арга хэмжээний үеэр хандивын арга хэмжээ зохион байгуулж арга хэмжээнд уригдсан зочид, тэдгээрийн гэр бүл болон компанийхаа зүгээс нийтдээ 28 сая төгрөгийн хандивыг амжилттай цуглуулж чаджээ. Хандивын арга хэмжээний үр дүнд олон олон хүүхдүүдэд амьдрал бэлэглэж, санхүүгийн боломжгүй байдлаас үүдэн бууж өгөхөөс аргагүй нөхцөлд байсан ээж аав, гэр бүлд тус болсондоо туйлын их баяртай байна. Porsche Улаанбаатар төв нь дараа дараагийн арга хэмжээндээ хүүхдийн боловсрол болон эрүүл мэндэд чиглэсэн хандивын арга хэмжээ үргэлж зохион байгуулахдаа таатай байх болно.

PWC

Төв болон Зүүн Европ бүсийн ("CEE") бизнесийн удирдагчид өсөлтийг өөдрөгөөр харж байгаа бөгөөд, тогтвортой үр дүнд хүрэх үүргээ нэмэгдүүлэх болно:

PwC ПидабалюСи "CEE"-ийн Гүйцэтгэх Захирлын судалгаа ("CEO") 2022

- Төв болон Зүүн Европ ("CEE" "Central and Eastern Europe")-ын "CEO" ("Chief Executive Officer" "Гүйцэтгэх захирал"-ын 68% нь ирэх онд дэлхийн эдийн засаг илүү хүчирхэг болно хэмээн таамаглаж байна. Мөн судалгаанд хамрагдсан нийт 85% нь компанийн орлого 2022 онд өснө гэж үзэж байна.,
- Бүс нутгийн удирдагчид өсөлтийн бүхий л боломжуудыг эрэлхийлж байна. Тухайлбал, Герман улс 2022 он тэдний хувьд өсөлтийн хамгийн чухал зах зээл байх болно үзсэн бол АНУ болон Хятад улсуудын хувьд энэхүү үзүүлэлтийн ач холбогдол өнгөрсөн жилийн үзүүлтээс буурсан байна.,
- Эрүүл мэндийн эрсдэл, кибер аюул, макро эдийн засгийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт зэрэг нь бизнест тулгарч буй гол асуудлуудын жагсаалтанд орж байгаа бөгөөд өнгөрсөн жилээс кибер аюул, уур амьсгалын өөрчлөлт зэрэг эрсдэлүүдийн талаарх ойлголтууд нэмэгдсэн байна.,
- Бүс нутгийн "CEO" нар нь уур амьсгалын өөрчлөлтийг хянахын тулд "Net-Zero" хүлэмжийн хийн ялгаруулалтыг эрс багасгах, нүүрстөрөгчийн саармаг байдалд шилжих амлалтуудыг нэмэгдүүлсэн. Хэдий тийм ч энэ асуудал дээр илүү сайжруулах боломж бий байгаа CEO санал нэгдсэн бол судалгаанд хамрагдан дөрөвний нэг хүрэхгүй хувь нь компаниудаа шинжлэх ухааны үндэслэлтэй амлалт өгсөн гэж онцолсон байна

2022 оны 1-р сарын 22: "COVID-19" цар тахал болон инфляцын өсөлт, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг зах зээлийн нөхцөл байдлын дарамт үргэлжилсээр байгаа хэдий ч "CEE" бүсийн "CEO" нар ирэх 12 сарын эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөвийг өөдрөгөөр харж байгаа бөгөөд ихэнх бизнесийн удирдагчид илүү тогтвортой үр дүнд хүрэхийн тулд байгаль орчин, нийгмийн асуудлуудад анхаарлаа хандуулж байна.

"CEE"-ын "CEO" нарын 68% нь ирэх онд тус үзүүлэлт сайжирна хэмээн үзэж байгаа бол дэлхий нийт хувьд эдийн засгийн өсөлт 77% гэж үзсэн. Мөн тухайн бүс нутгийн бизнесийн лидерүүд ирэх жил компанийнхаа орлогыг өсгөх чадварт илүү итгэлтэй байна. Тэдний 84% нь өөрсдийн компанийн өсөлт, хөгжлийн хэтийн төлөвт итгэл тогтсон байгаагаа илэрхийлж байгаа боловч дэлхийн нийтийн үзүүлэлт 85% бага зэрэг хоцорсон байдал ажиглагдаж байна.

Дээрх үзүүлэлтүүд нь 2021 оны 10 болон 11-р сарын хооронд дэлхийн нийт 89 улсын 4,446 гүйцэтгэх захирлуудын дунд санал асуулга явуулсан PwC-ийн 25 дахь удаагийн "CEO" нарын судалгааны "CEE" бүсийн гол дүгнэлтүүдийн нэг юм. Үүнд тухайн бүс нутгийн 178 "CEO"-ын дэд түүвэр багтсан болно.

"CEE" бүсийн гүйцэтгэх захирлууд өсөлттэй байх магадлалтай газрыг судалж үзэхэд Герман улс хамгийн тогтвортой буюу 38%-тай хэвээр байсаар байна. Дэлхийн хэмжээнд АНУ 41%-ийн өсөлттэй буюу хамгийн чухал зах зээл гэж тооцогдох хэвээр байгаа бол Хятад (27%) удаалж, Герман гуравдугаарт (18%) орж байна.

Энэхүү судалгааг өнгөрсөн жилийн судалгааны үр дүнтэй харьцуулбал тухайн бүс нутгаас динамик өөрчлөлтийг харж болохоос гадна хамгийн их ашиг олох боломжтой газар хэмээн "CEO" нар үзэж байна. ХБНГУ-ын үүрэг "CEE"-д нэмэгдэж (2021: 28%), АНУ буурч (2021: 23%), Хятад 2022 онд 18%-иас 12% хүртэл буурсан байгаа нь сонирхолтой байна. Учир нь дэлхийн хэмжээний үнэлгээ өмнөх оныхтой төстэй хэвээр байгаа бөгөөд АНУ 35% -иас 41%, Герман 17% -иас 18% болж, Хятад 2022 онд 28%-иас 27% болж бага зэрэг буурчээ.

PwC-ийн Төв ба Зүүн Европын ("CEE") Гүйцэтгэх захирал Ник Кос мэдэгдснээр: "Цар тахлын нөлөө үргэлжилсээр байгаа тул "CEO" нар бүх талын дарамт, тодорхойгүй байдалтай тулгарсаар байна. Гэсэн хэдий ч тухайн бүс нутагт манай бизнесийн удирдагчид эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр төсөөлж байна. Мөн гүйцэтгэх захирлууд эдгээр сорилтуудыг амжилттай даван туулж чадна гэдэгт итгэлтэй байгаа нь ашгийн өсөлтийн төлөв нэмэгдсэнийг харахад бид таатай байна. Бид "шинэ хэвшил" байдалдаа дасан зохицож байна. Мөн цаашид саад бэрхшээл тулгарах боловч ихэнх "CEO" нар итгэл найдвар дүүрэн хэвээр байгаа нь урам зориг өгч байна."

Цахим, уур амьсгал, эрүүл мэндийн эрсдэл зэрэг нь "CEO" нарын анхаарах үндсэн асуудлыг нэг болж байна:

"CEO" нар ихэнх тал дээр өөдрөгөөр харж байгаа ч ирэх 12 сарын хугацаанд компаниудад нөлөөлж болзошгүй эрсдэлүүдэд бэлтгэлтэй байгаа.

"CEE"-ын бизнесийн өсөлтөд учирч буй гол эрсдэлүүд нь өнгөрсөн жилтэй харьцуулахад дэлхийн бусад орнуудын хариутай илүү нийцэж байна. "CEE"-ын "CEO" нарын санааг зовоож буй хамгийн том асуудал бол эрүүл мэндийн эрсдэл (53%) ба макро эдийн засгийн тогтворгүй байдал (48%), кибер аюулгүй байдал (40%), үүний дараагаар уур амьсгалын өөрчлөлт (33%) орж байна. Харин дэлхий нийтийн хэмжээнд кибер аюулгүй байдлын асуудал тэргүүлж (49%), эрүүл мэндийн эрсдэл (48%) буюу бараг л үндсэн асуудлын нэг болж байгаа бол макро эдийн засгийн тогтворгүй байдал (43%), дараа нь уур амьсгалын өөрчлөлт (33%) гэсэн тус тус үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн жилийн "CEO"-ын судалгааны үр дүнтэй харьцуулахад цахим эрсдэл болон уур амьсгалын өөрчлөлт нь бүс нутгийн удирдагчдын эрсдэлийн жагсаалтад илүү байр ахисан байна. 2021 онд "CEO" нарын ердөө 33% нь бизнест нь халдах кибер аюулын талаар санаа зовниж байсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлт нь эхний таван асуудлын тоонд багтаагүй байсан байна. Цар тахлын хойшлуулшгүй нөхцөл байдал "CEO" нарын санааг зовоосоор байгаа нь тоон үзүүлэлтээс илт харагдаж байна. Гэвч илүү олон удирдагчид бидний улам бүр ээдрээтэй бөгөөд дижиталчлагдаж буй ертөнцөд бизнест тулгарч буй ирээдүйн сорилтуудын үр нөлөөг бууруулахын тулд кибер аюулгүй байдал, хувь хүний нууцын мэдээлэлд илүү их найдах төлөв ажиглагдаж. ПидабалюСи-ийн 2022 оны "Digital Trust Insights-Дижитал итгэлцэл ба статистик" судалгаанд

"CEE"-ын "CEO"-ын 50 гаруй хувь нь цахим орчны хэт ээдрээтэй байдал нь тэдний бизнест эрсдэл учруулах түвшинд хүргэж байна гэж хариулжээ. Гэсэн хэдий ч 20 хүрэхгүй хувь нь цахим хялбарчлалд оруулсан өмнөх хөрөнгө оруулалтын үр ашгийг ойлгосон нь кибер аюул болж өсөхийн зэрэгцээ тус бүс нутгийн "CEO" нар өөрсдийн тогтолцоонд тулгарч болзошгүй эрсдэлийг зохицуулахаар хичээж байгааг харуулж байна.

Дэлхий дахинд тус үзүүлэлт нь санхүүгийн үйлчилгээний "CEO" нарын хувьд кибер аюулгүй байдлын эрсдэл хамгийн их байдаг бөгөөд тэдний 59% нь цахим эрсдэл нь нэн чухал эрсдэл хэмээн нэрлэжээ. Үйлдвэрлэлийн салбар (40%), хэрэглэгчдийн (39%) цахим халдлагад өртөж буй салбаруудын тоо хэмжээ их байгаа ч эдгээр салбаруудын "CEO" нар цахим халдлагыг чухалчлан авч үзэх түвшин доогуур байгааг тэмдэглэсэн ба ирэх онд харьцангуй тайвшрах байдал үүсэх эсэхийг ажиглах хэрэгтэй онцолсон.

Зочид буудал, амралт зугаалгын салбарын "CEO" нарын дийлэнх (75%) нь өөрсдийнхөө бизнест нөлөөлөх эрүүл мэндийн эрсдэлийн талаар санаа зовниж байгаа нь судалгаанаас илүү тодорхой байна. Мөн эрчим хүч, нийтийн аж ахуй, нөөцийн "CEO" нарын 49% нь уур амьсгалын өөрчлөлтийг ирэх оны хувьд гол аюул заналхийлэл гэж үзэж байгаа нь бусад салбаруудын үзүүлэлтээс 15 оноогоор илүү өндөр байна.

Ник Кос, PwC-ийн Төв ба Зүүн Европын Гүйцэтгэх захирал хэлэхдээ: "CEO" нар бидэнд тулгарч буй дэлхий нийтийн сорилтуудад илүү бодитой ханддаг. Гэвч 2022 онд тулгарах томоохон эрсдэлүүдийг үл харгалзан "CEE"-ын гүйцэтгэх захирлууд уур амьсгалын өөрчлөлт зэрэг дэлхий нийтийн асуудлуудыг шийдвэрлэх, болоод өсөлтийн хэтийн төлөвтөе итгэлтэй хэвээр байна. Дэлхий дахинд тулгамдаж буй томоохон асуудлууд дээр хамтдаа ханцуй шамлан орж байгааг бид харж байна. Хэдий тийм ч бүс нутагт "CEO" нар үүргээ биелүүлэхийн тулд илүү уян хатан, идэвхтэйгээр тухайн сорилтод хандах хэрэгтэй болно."

Санхүүгийн бус үр дүн ба итгэлцэл

Тулгарч буй асуудлуудаас харахад "CEE" бүсийн гүйцэтгэх захирлууд уур амьсгалын өөрчлөлт, цар тахал зэрэг дэлхий нийтэд тулгамдаж буй сорилтуудын эсрэг арга хэмжээ авахад ямар үүрэг гүйцэтгэх ёстойг ойлгож эхэлж байгаа бололтой. Итгэлцэл бол компанийн амжилтад маш чухал үзүүлэлт байсаар ирсэн бөгөөд үүнийг тогтвортой хадгалахад улам хэцүү байдаг. Компанийн урт хугацааны стратегид ямар үр дүн үзүүлэх нь "CEO" нарын хувьд урт хугацааны урамшуулалын төлөвлөөнд тусгагдсан болохыг зураглаж үед сонирхолтой дүр зураг гарч ирдэг.

Урт хугацааны урамшууллын хөтөлбөртэй холбоотой санхүүгийн бус үр дүнгийн хувьд "CEE"-ын тоо баримтууд нь дэлхийн бусад мэдээлэгдсэнтэй давхцах буюу эсвэл давсан үзүүлэлттэй байна. Үүнд: дараах үзүүлэлтүүд орно. "Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн хэмжүүр" ("CEE": 37%; дэлхийн: 39%), "Ажилчдын оролцооны сэтгэл ханамж" ("CEE": 37%; дэлхийн: 36%), "Автоматжуулалт ба дижиталчиллын зорилтууд" ("CEE": 30%; дэлхийн: 23%). Эдгээр нь бизнест суурилсан санхүүгийн бус үр дүнгийн хэмжүүрүүд маргаангүй мөн тул бүх "CEO" нарын зүгээс хамгийн их дурдагдсанд гайхах зүйлгүй.

Нөгөө талаар, дэлхий дахинд бага харин "CEE"-д харьцангуй цөөн тооны "CEO" нар өөрсдийн хувийн урамшуулал эсвэл урамшууллын төлөвлөгөө нь "Жендэрийн төлөөллийн түвшин"-ийн шинээр гарч ирж буй санхүүгийн бус үр дүнтэй холбоотой гэж мэдээлсэн" нь ("CEE": 7%; дэлхийн: 11%), "Хүлэмжийн хийн ялгаруулалтын зорилтууд" ("CEE": 10%; дэлхийн: 13%), "Арьс өнгө, гарал үүслийн төлөөллийн түвшин" ("CEE": 2%; дэлхийн: 8%) байна.

Урамшууллын төлөвлөгөөнд санхүүгийн бус үр дүн нь илүү гарч ирж буй "CEO" нарын үйлчлүүлэгчид тэдэнд илүү итгэдэг гэж дэлхийн хэмжээнд ойлгодог. Энэ логикоор "ESG"- Environmental, Social, and Governance" (Байгаль орчин, Нийгэм болон Засаглал) хэмжигдэхүүнийг гүйцэтгэх албан тушаалтнуудын цалинтай уялдуулах нь "CEO" нар "ESG"-ийн үүрэгтээ хэр нухацтай ханддагийг үйлчлүүлэгчдэд таниулахад тустай байж болох ч энэ нь зөвхөн үйлчлүүлэгчдэд үнэнч байдаг байдлыг харуулж байна. "ESG" хувьд бодит үр дүнд хүрэхийн тулд гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулалд байгууллагын стратеги бодлогыг дагаж мөрдөх шаардлагатай. "ESG" хэмжүүрүүд нь компанийн стратегийн санаачлага болон тэргүүлэх зорилтуудын нэг хэсэг байх ёстой бөгөөд давхар урамшууллаар дэмжигдэх нь зүйтэй гэдгийг саяханы PwC report-д үр дүн харуулсан.

Уур амьсгалын өөрчлөлт нь чухал асуудал боловч "Net-Zero" амлалтуудыг боловсронгуй болгож болно

Судалгаанаас харахад "CEE" бүс нутгийн "CEO" нар зарим үзүүлэлтүүд дээр дутмаг байгаа ч нүүрстөрөгчийн хийг саармагжуулах үүрэгт ажлаа дэлхийн хэмжээнд хавьгүй ижил түвшинд биелүүлж байна. Гэхдээ эдгээр ажлыг хэрхэн хэмжиж, урамшуулах тухай зарчмыг "CEE"-ын бизнесүүдэд сайжруулах боломжтой гэж тэд үзсэн хэвээр байна.

Нүүрстөрөгчийн хий ялгаруулахгүй байх үүрэг хүлээсэн "CEE"-ын "CEO" нарын өзлэх хувь дэлхийн түвшний хэмжээнд нийцэж байгаа (26%)-тай байна. Бүс нутгийн удирдагчид илүү санаачлагатай "Net-Zero" амлалт өгөх тал дээр бага зэрэг хоцорч байгаа бөгөөд хэр нарийвчлалтай амлалт өгсөн талаар асуулга явуулахад дэлхийн хэмжээний 22%-тай харьцуулахад "CEE" бүсийн "CEO" нар 19%-тай судалгаанд хариулжээ.

"CEE" бүс нутгийн "CEO" нар нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг бууруулах арга замыг эрчимтэй хайж байгаа боловч, тухайн үүргийг хүлээсэн бизнесүүдийг илүү ойроос харахад шинжлэх ухааны үндэслэлтэй зорилтуудыг тавих магадлал бага байна. Мөн тэд санхүүгийн бус үр дүнг өөрсдийн урамшууллын багцтай холбох магадлал багатай байна. Дэлхийн хэмжээний 11%-тай харьцуулахад "Net-Zero" амлалт өгсөн "CEE" бүсийн "CEO" нарын 23% нь шинжлэх ухаанд суурилсан аль зорилттой нь нийцэж байгаа эсэхийг сайн мэдэхгүй хэмээн хариулжээ.

Шинжлэх ухаанд суурилсан зорилт үгүй бол "CEE"-ийн удирдагчид өөрсдийн "Net-Zero" амлалтын талаар ахиц дэвшлийг хэмжихэд илүү хэцүү байх болно гэж үзэж байна. Харин дэлхийн тоо баримтаас харахад томоохон компаниуд шинжлэх ухаанд суурилсан зорилтыг хэрэгжүүлэхэд өндөр төлөөлөл болж байгааг харуулж байна; 25 тэрбум доллар ба түүнээс дээш орлоготой компаниудын бараг гуравны хоёр нь

CEO optimism about global growth builds, despite dips in several major economies

Question: How do you believe global economic growth (i.e., gross domestic product) will change, if at all, over the next 12 months?

(Showing only 'improve' responses)



Source: PwC 25th Annual Global CEO Survey
www.ceosurvey.pwc
© 2022 PwC. All rights reserved.

No matter the threat, CEOs are most concerned about near-term impact to the top line

"It could inhibit our ability to..."

Question: How do you anticipate your company could be impacted by these threats over the next 12 months?

(Showing only responses from CEOs who were 'very concerned' or 'extremely concerned' about each threat)



Source: PwC 25th Annual Global CEO Survey
www.ceosurvey.pwc
© 2022 PwC. All rights reserved.

Note: Not showing responses for 'It could inhibit our ability to develop products/services'

"Net-Zero" амлалтыг өгсөн бол 100 сая долларaас бага ашиг орлоготой компаниудын 10% амлалт өгсөн байна. Мөн манай жишиг олон нийтийн компаниуд хувийн компаниудаас "Net-Zero" үүрэг хүлээсэн байх магадлал хоёр дахин их байна. Эдгээр үр дүн нь ихэвчлэн олон нийтэд мэдэгдэл хийж анхааруулдаг ба: доривтой арга хэмжээ авах шаардлагатайг илүү ухамсарладаг, илүү их орлого, нөөцтэй байх хандлагатай компаниудын удирдагчид хамгийн их дуугарч, идэвхтэй байдаг.

"CEE" бүсэд багтах улсуудын бизнес дэлхийн бусад төстэй бизнесүүдтэй харьцуулахад харьцангуй залуу хэвээр байна. Гэсэн хэдий ч, Европийн Холбооны шинэ хууль тогтоомж удахгүй гарахтай хобоотойгоор "Net-Zero" үүрэг хүлээсэн бизнес эрхлэгчдэд тухайн ажлыг тайлагнах зайлшгүй шаардлага бий болж, нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг илүү чухалчлах болно.

Татварын хариуцлагатай байдлаар нөлөөлөл бий болгох нь

Байгаль орчин, нийгэм, засаглал буюу "ESG"-ийн хүлээсэн үүрэг нь нийгэмлэг болон бизнест итгэлцлийг бий болгож, нийгэмд тогтвортой үр дүнд хүрэхэд хувь нэмрээ оруулах цорын ганц арга зам биш болно. "CEE" бүсийн бизнесийн удирдагчид бизнесийн нийгэмлэгийн нийгэмд оруулж буй хувь нэмэр болох өөр нэг хөшүүрэг буюу татварын тал дээр илүү идэвхтэй байдаг.

Өргөн утгаар нь авч үзвэл, "CEE" болон дэлхийн хэмжээнд компанийн ТУЗ-үүд татварын стратегийг хянахад адил түвшинтэй төвлөрч байгаа боловч татвартай холбоотой өөр гурван асуултын хариултууд зөрүүтэй байна. Тухайлбал, хариултууд нь "CEE"-ийн "CEO" нар дэлхийн нэг үеийнхнээсээ илүү татварын хариуцлагын талаар ил тод байр суурьтай байдгийг харуулж байна. Дэлхий хэмжээнд "CEO" нарын 37% нь компанийнхаа төлж буй татварын хэмжээг багасгахыг зорьж байгаатай хатуу эсвэл дундаж байр суурьтай буйгаа илэрхийлсэн бол "CEE"-ын гүйцэтгэх захирлуудын ердөө 28% нь үүнтэй адил байр суурьтай байгаа хэмээн хариулжээ. Дэлхийн хэмжээний 33%-тай харьцуулахад тухайн бүсийн "CEO" нарын 49% нь өөрсдийн компанийн төлж буй бүх татвараа олон нийтэд ил тод мэдээлдэг гэдэгт хатуу эсвэл дундаж байр суурьтай байгаагаа илэрхийлсэн. Эцэст нь, "CEE" бүсийн "CEO" нар төлж буй татварын хэмжээ болон нэр хүндийн эрсдэл хоёрын хоорондын уялдаа холбоог дэлхийн хэмжээнд ижил салбарынхнаасаа илүү чухалчилдаг болохыг онцолсон (Дэлхийн хэмжээний үзүүлэлт нь ердөө 20% байхад тухайн бүс нутагт 27% нь "хүчтэй" эсвэл "дунд зэрэг" чухалчилдаг гэсэн үзүүлэлттэй байна). "CEE"-ын судалгааны үр дүнг эндээс үзнэ үү https://www.pwc.com/c1/en/25th-ceo-survey-cee.html.

PwC нь 2021 оны 10 болон 11-р сард дэлхий 89 улсын 4,446 "CEO" Гүйцэтгэх захируудаас авсан ярилцлагад үндэслэн гарсан судалгаа болно. Тус судалгаа нь "CEO" нарын үзэл бодлыг бүхий л томоохон бүс нутгуудад төлөөлөхийн тулд энэхүү тайланд дэлхийн болон бүс нутгийн тоон үзүүлэлтүүдийг тухайн улс эсвэл бүс нутгийн нэрлэсэн ДНБ-тэй пропорциональ байдлаар тодорхойлсон болно. Салбар болон улс орны түвшний тоон үзүүлэлтүүдийг 4,446 "CEO"-ын бүрэн түүврээс авсан мэдээлэлд үндэслэсэн болно. Дэд түүвэр буюу "CEE" Төв болон Зүүн Европын 178 гаруй "CEO" багтсан байна. Бүс нутаг, улс орон, салбарын дэлгэрэнгүй мэдээллийг хүсэлтийн дагуу авах боломжтой. Ярилцлагын 94% онлайнаар, 6% шуудангаар, утсаар болон нүүр тулан ярилцан авсан ба бүх тоон үзүүлэлттэй ярилцлагыг нууцлалын үндсэн дээр хийсэн. Мөн бид дэлхийн таван бүс нутгийн (Хойд Америк, Латин Америк, Баруун Европ, Ази Номхон далай, Африк) "CEO" нартай нарийн нягт ярилцлага хийхээс гадна эдгээр ярилцлагын заримыг энэхүү тайланд иш татсан болно; ихэнх ярилцлагыг бүрэн эхээр нь strategy-business.com/mindoftheceo дээрээс уншиж танилцах боломжтой.

PwC-ийн тухай

PwC компанийн зорилго бол нийгэмд итгэх итгэлцлийг бий болгож, чухал асуудлуудыг шийдвэрлэх явдал юм. Бид дэлхийн 156 орны 295,000 гаруй ажилагдсадтайгаар аудит, мэргэжлийн зөвлөгөө, татварын үйлчилгээг чанартай хүргэх зорилготой сүлжээ фирм. www.pwc.com хаягаар зочлон, илүү ихийг олж мэдэх боломжтой ба та өөрийн асуултын талаар бидэнд хандаарай. www.pwc.com.

PwC нь PwC сүлжээ болон/эсвэл тус бүр нь тусдаа хуулийн этгээд болох нэг буюу хэд хэдэн гишүүн байгууллагыг хэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг www.pwc.com/structure дээрээс авна уу.

Firms without decarbonisation commitments cite lack of emissions—and capabilities

Question: How accurate are the following statements regarding why your company has not made a carbon-neutral or net-zero commitment?

(Showing only 'very accurate' and 'extremely accurate' responses)



Source: PwC 25th Annual Global CEO Survey
www.ceosurvey.pwc
© 2022 PwC. All rights reserved.

Notes: GHG = greenhouse gas

Despite rising interest in ESG, strategy is still primarily driven by business metrics

Question: Are the following non-financial-related outcomes included in your:
a) company's long-term corporate strategy?
b) personal annual bonus or long-term incentive plan?

Source: PwC 25th Annual Global CEO Survey
www.ceosurvey.pwc
© 2022 PwC. All rights reserved.

ОЮУ ТОЛГОЙ" КОМПАНИ "НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ-2021

"ӨМНИЙН ГОВИОС ДЭЛХИЙН ТАВЦАНД ХАМТДАА"

"Оюу толгой" компани нь орон нутгийн удирдлага, ард иргэдтэй бүх түвшинд тогтмол харилцаатай ажиллах зорилгынхоо хүрээнд хамтын ажиллагаа, түншийн харилцаагаа улам бэхжүүлэх, үйл ажиллагаагаа танилцуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Нээлттэй Өдөрлөг"-ийг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай.

Сэндвик Монголиа компани нь Оюу Толгой компанийн үйл ажиллагааг дэмжин хамртан ажиллаж уг өдөрлөгт оролцон 12 дугаар сарын 04-н болон 06-ны өдрүүдэд Даланзадгад, Ханбогд сумдад компанийн үйл ажиллагаагаа танилцуулан, нээлттэй ажлын байруудад нөөц бүрдүүлэлт хийх зорилгоор оролцлоо.

БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГТ ОРОЛЦЛОО

2021 оны 11 дүгээр сарын 19-нд "Улаанбаатар дахь Бритиш сургууль"-иас зохион байгуулсан "Боловсролын Үзэсгэлэн"-нд Сэндвик Монголиа компани амжилттай оролцлоо. Энэхүү үзэсгэлэн яармагт "Улаанбаатар дахь Бритиш сургууль", "Орчлон", "Шинэ Монгол Харумафүжи" зэрэг ерөнхий боловсролын сургуулиудын нийт 100 орчим сурагчид хамрагдсан байна.

Тус үзэсгэлэн нь удахгүй мэргэжил сонголт хийх гэж байгаа 15-18 насны сурагчдад ирээдүйн мэргэжлээ сонгоход нь туслалцаа, мэдээлэл өгөх зорилготой байсан юм. Монгол Улсад суугаа орон орны Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагууд, бизнесийн аж ахуйн нэгжүүдээс бүрдсэн 40 гаруй байгууллага уг арга хэмжээнд оролцжээ.

Уул Уурхайн салбарын төлөөллийн хувьд бид Монгол улс дахь Уул уурхайн салбарын өнөөгийн чиг хандлага болон Сэндвик Групп, Сэндвик Монголиа компанийнхаа талаар танилцуулж, дадлагын болон шинэ төгсөгчдийн хөтөлбөрийн талаар мэдээлэл өгсөн юм.

ХҮҮХДИЙН НОМЫН САНД ТАВИЛГА ХАНДИВЛАЛАА

Нарны хүүхдүүд цэцэрлэгт суралцагч хүүхэд багачууд, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагчид болон СХД-ийн иргэд, олон нийтэд номын сангийн үйл ажиллагаагаар дамжуулан номын зохистой хэрэглээг хэвшил болгох зорилгоор Вэлүү Сангаас санаачилсан "Гандисийн Хүүхдийн Номын Сан"-гийн нээлт 2021 оны 10-р сарын 25-нд зохион байгуулагдлаа.

"Сэндвик Монголиа" ХХК нь уг номын сангийн үйл ажиллагааг дэмжих, номонд шимтэгч хүүхэд багачууддаа тохилог орчныг бий болгоход нь туслалцаа үзүүлэх үүднээс номын санд тавилга хандивлаж энэхүү санаачлагад нэгдсэндээ таатай байна.

Гандисийн Хүүхдийн Номын Сан, Вэлүү Сан, болон уг санаачлагад нэгдэж хандив туслалцаа үзүүлсэн бусад байгууллагуудад цаашдын ажилд нь өндөр амжилт хүсье.



63-Р СУРГУУЛЬ БОЛОН 10-Р ЦЭЦЭРЛЭГТ ТАВИЛГА ХАНДИВЛАЛАА

Сэндвик Монголиа ХХК нь нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд "Монголын Аутизмын Холбоо"-оор дамжуулан Нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх 63-р сургуулийн "Багш хөгжлийн танхим"-д болон Баянзүрх дүүргийн 10-р цэцэрлэгт тавилга хандивлалаа.

63-р сургууль нь оюуны бэрхшээлтэй сурагчдыг сургаж, тусгай хэрэгцээт боловсрол олгодог Монгол Улс дахь цөөхөн ийм төрлийн сургуулийн нэг юм.

2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн 10-р цэцэрлэг нь хүнд болон хүндэвтэр хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургаж сэргээн засах үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд одоогоор 120 хүүхэд, 48 ажилтан суралцаж, ажиллаж байна.

Тус сургууль, цэцэрлэгийн багш сурган хүмүүжүүлэгчид болон нийт сурагчиддаа цаашдын сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье!

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ДҮРЭМТ ХУВЦАС ХАНДИВЛАЛАА

Шинэ хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан "Сэндвик Монголиа" ХХК нь "Кристина Ноблийн Хүүхдийн сан"-гаас санаачилсан ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа эмзэг бүлгийн хүүхдүүдэд сургуулийн дүрэмт хувцас болон хичээлийн хэрэгсэл хандивлах аянд нэгдэж сургуулийн дүрэмт хувцас хандивлалаа.

СЭНДВИК МОНГОЛИА ХХК ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЭРЭГСЭЛ ХАНДИВЛАЛАА

"Зовох цагт нөхрийн чанар" танигдана гэж ардын зүйр үг байдаг. Үүнтэй ижлээр КОВИД-19 цар тахлын онцгой нөхцөлд нийгэмдээ бидний үзүүлж болох үр нөлөө багагүй.

КОВИД-19 цар тахал нь төрийн болон хувийн хэвшил, орон нутгийн болон олон улсын байгууллагууд бие биенээсээ хэр их хамааралтай болохыг харуулж байна. Халдварыг нэг байгууллага дан ганцаараа зогсоож чадахгүй нь ойлгомжтой.

Эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон халдвар цааш тархахыг сэргийлэхээр ажиллаж буй төрийн албан хаагчид хувийн хамгаалах хэрэгсэл, гар ариутгагч, маскгүйгээр ажлаа аюулгүй гүйцэтгэж чадахгүй.

Тиймээс Сэндвик Монголиа ХХК нь Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын харьяа, Ханбогд суман дахь Гал унтраах, аврах 66-р ангийн КОВИД-19 цар тахалтай тэмцэх шуурхай штаб-т 5 сая төгрөгийн үнэ бүхий халдвар хамгааллын хэрэгслийг хүлээлгэн өглөө. Монгол улсынхаа хүн ардын эрүүл мэндийн төлөө өдөр, шөнийг ялгалгүй ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнд талархлаа илэрхийлье.

ГОВЬ ГАЛЛОП - 2021 ХАНДИВЫН АРГА ХЭМЖЭЭ

Сэндвик Монголиа компанийн гүйцэтгэх захирал Брэд Кларк "Говь Галлоп 2021" хандивын арга хэмжээнд амжилттай оролцлоо.
Энэхүү арга хэмжээ нь Велүү сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг тэсвэр тэвчээр шалгасан морин аялал бөгөөд уг арга хэмжээгээр цугласан хандивыг эмзэг бүлгийн хүүхэд багачуудын боловсрол, цаашдын ирээдүйн сайн сайханд чиглэсэн ажлуудад зарцуулдаг юм.
Одоогийн байдлаар Брэд 4000 орчим ам/доллар-ын хандивыг босгосон байгаа бөгөөд үүнийг "Нарны хүүхдүүд"-цэцэрлэгт сурч боловсорч байгаа эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсрол, ирээдүйн сайн сайханд зарцуулах болно.

СЭНДВИК МОНГОЛИА ЭМЗЭГ БҮЛГИЙН 200 ӨРХӨД ХҮНСНИЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ

Дэлхийд тэргүүлэгч Сэндвик группийн ажилтан, нийгмийн хариуцлагаа ухамсарладаг сайн иргэдийн хувьд бид өөрийн эргэн тойрондоо үргэлж эерэг өөрчлөлтийг дагуулж, шаардлагатай тохиолдолд тусламжийн гараа сунгахад бэлэн байдаг.
Коронавируст халдварын цар тахал дотоодод дэгдэж, Монгол Улсын Засгийн Газар, Улсын Онцгой Комиссын шийдвэрээр "Бүх нийтийн бэлэн байдал"-ын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосон үед "Сэндвик Монголиа" ХХК нь Монголын улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран 200 өрхөд хүнсний тусламж үзүүллээ.
Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн хүнсний тусламж нэн шаардлагатай зорилтот бүлгийн 200 өрхөд Шинэ жилийн баярын өмнө хүнсний тусламжийн тараалтыг амжилттай түгээж дуусла.
Хүнсний тусламжийг 16 хүртэлх насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүл, жирэмсэн эсвэл хөхүүл хүүхэдтэй гэр бүр, 60-аас дээш насны харж хандах хүнгүй ахмад настан, 16 хүртэлх насны 5-аас дээш хүүхэдтэй өрх болон төрөөс олгож буй хүнсний талонд хамрагдаагүй, өрхийн орлого нь зогссон, тодорхой хаяг бүртгэлгүй, гэр оронгүй, хүнсний дутагдалд орсон өрхүүдэд олгосон юм.
Нэг өрхөд олгосон хүнсний багцад 20 кг гурил, 5 кг цагаан будаа, 2 кг сахар, 3 кг гоймон, 1 кг давс, 1 л ургамлын тос, цай 1 ширхэг гэх зэрэг хурдан муудахгүй, тээвэрлэлтийн горим шаардахгүй хүнсний бүтээгдэхүүнүүд багтсан юм.

Халдварын эсрэг хамтдаа!

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМАНД 100 МОД ТАРЬЛАА

Өмнөговь аймгийн 90 жилийн ойг тохиолдуулан 90,000 мод тарих санаачилгад "Сэндвик Монголиа" ХХК нэгдэж 100 ширхэг модны суулгацыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын ногоон байгууламжид суулгалаа.
Тухайн арга хэмжээ нь 2021 оны 05-р сарын 1-ний Бямба гаригт зохион байгуулагдсан бөгөөд Сэндвик Монголиа компаниа төлөөлж Ханбогд сум дахь салбар агуулахын дөрвөн ажилтан маань оролцон мод тарьсан юм. Бид үйл ажиллагаа явуулж буй орон нутгийнхаа байгаль хамгаалал, нөхөн сэргээлт тал дээрх аливаа санал санаачлагыг идэвхтэй дэмжин ажилладгаа энэ үйлдлээрээ бататган харууллаа.
Энэ завшааныг ашиглан мод тарих аяныг дэмжин ажилласан Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг Даргын Тамгын Газарт болон Ханбогд салбар Агуулахын ажилтнуудаа талархал илэрхийлье!

SANDVIK MONGOLIA LLC

МАНАЙ АЖИЛТНУУД БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦЛОО

Ханбогд сумын Засаг Даргын Тамгын газраас санаачилсан бүх нийтийн их цэвэрлэгээнд Ханбогд салбар агуулахын ажиллагсад идэвхитэй хамрагдаж үйл ажиллагаа явуулж буй албан байгууллагынхаа ойр орчмын 50 метр газарт их цэвэрлэгээ хийлээ. Мөн сумын захиргааны хүсэлтийн дагуу Шар дов хорооллын 1, 2, 3, 4-р гудамжны айлуудтай нэг бүрчлэн уулзаж цэвэрлэгээнд оролцохыг уриалжээ.
Бид үйл ажиллагаа явуулж байгаа газар бүртээ сайн үлгэр дууриаллыг үзүүлдэг. Цэвэрлэгээнд оролцсон нийт залуучуудаараа бахархаж байна.

СЭНДВИК МОНГОЛИА ХХК "ИТГЭЛ НАЙДВАРЫН ТӨЛӨӨХ ХҮҮХДҮҮДИЙН АЛХАЛТ" ХАНДИВЫН АЯНД НЭГДЛЭЭ

Сэндвик Монголиа ХХК нь Кристина Ноблийн хүүхдийн сангаас санаачлан зохион байгуулсан "Итгэл найдварын төлөөх хүүхдүүдийн алхалт" хандивын аянд нэгдэж мөнгөн хандив өргөлөөц.
Кристина Ноблийн Хүүхдийн Сан нь 30 гаруй жилийн турш хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэл, мөлжлөг, наймааг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагааг Монгол болон Вьетнам улсад явуулсаар ирсэн билээ.
Тэгвэл уг сан нь энэ удаагийн "Итгэл найдварын төлөөх хүүхдүүдийн алхалт" цахим хандивын арга хэмжээг дэлхийн 17 улсад зэрэг нэг өдөр буюу 5-р сарын 23-ны Ням гаригт зохион байгуулснаараа онцлог. Хандивын арга хэмжээгээр цугларсан нийт санхүүжилтийг тусламж нэн шаардлагатай байгаа, эмзэг бүлгийн бага насны хүүхдүүдийн асран хамгаалал, боловсрол, болон цаашдын сайн сайхны төлөө зарцуулах зорилготой.
Хүүхэд бүр хамгаалагдах, аюулгүй орчинд сурч боловсрох, гэрэлт ирээдүйд хүрэхэд шаардагдах боломж бололцоогоор хангагдах ёстой гэдэгт Сэндвик Монголчууд бид итгэдэг. Тэрч утгаараа 6-р сарын 1-ний өдөр буюу Хүүхдийн эрхийг хамгаалах баярын өдрийн өмнө уг хандивын арга хэмжээнд нэгдсэндээ бид сэтгэл хангалуун байна.
Бидний ирээдүй хүүхэд багачууд!

ХАРАААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИЖ КОМПЬЮТЕР ХАНДИВЛАЛАА

Сэндвик Монголиа ХХК нь Эмэгтэйчүүдийн Манлайллын Хөтөлбөрийн хүрээнд "Үеийн тэгш байдал" багийн санаачилсан харааны бэрхшээлтэй хүмүүст боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэн, хүртээмжтэйгээр хамруулах "Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан англи хэлний сургалт"-ыг дэмжин зөөврийн болон ширээний компьютер хандивлалаа.

“ТИЙСС ХИШИГ АРВИН ЖЕЙВИ” ХХК ГОВЬ НУТГИЙН МАЛЧДАД НЭН ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ

Тийсс компани болон үндэсний оператор Хишиг Арвин Индустриал ХХК хамтран Өмнөговь аймгийн гүний 20 худагт нарны эрчим хүчээр ажилладаг шахуурга суурилуулж өгсөн нь орон нутгийн малчдад усны хэрэгцээгээ хангахад нэн чухал дэмжлэг боллоо.

Нарны эрчим хүчээр ажилладаг эдгээр шахуурга нь Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо болон Манлай сумын 120 малчин айл өрхийн ундны ус авах, 42,500 гаруй толгой мал услах ажлыг хөнгөвчилж байгаа юм.

Тийсс компанийн Төр, орон нутагтай харилцах албаны менежер Ц.Батхүү хэлэхдээ, “Бид үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, амьдрал ахуйд дэм болохуйц олон санал санаачилгыг хэрэгжүүлэх замаар орон нутагт урт хугацааны тогтвортой үр өгөөжийг бий болгохыг зорин ажилладаг юм.

Нутгийн малчдын ашигладаг гүний худгуудад шахуурга суурилуулж өгсөн нь нэн тулгамдсан чухал асуудлыг богино хугацаанд шийдвэрлэсэн явдал боллоо. Бидний хэрэгжүүлсэн энэ ажлын үр дүнд отор нүүдлийн үед төдийгүй жилийн дөрвөн улиралд ч малчид малаа хялбар услах боломж бүрдэж байна” хэмээн онцлов.

Байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай, нарны эрчим хүчээр ажилладаг шахуургуудыг суурилуулсан нь нутгийн малчин иргэдэд жилийн аль ч улиралд усаа хялбар авах боломжийг бүрдүүлж өгсөн юм. Эдгээр нь малчдын цаг, хөдөлмөрийг ихээхэн хэмнэж байгаа тул тэд ихэд талархан хүлээн авчээ.

Өмнө нь малаа услахад хүч хөдөлмөр ихээхэн шаарддаг байсан ажлыг нарны эрчим хүчээр ажилладаг шахуурга суурилуулан хөнгөвчилж өгсөн тухай малчин Баттөмөр талархан өгүүлсэн юм.

Тэрбээр хэлэхдээ, “Өмнө нь малаа услах нь хүнд хөдөлмөр шаардсан ажил байсан. Өвлийн улиралд малаа услахын тулд хөлдүү мотор асаах гэж удаан ноцолдож, адуу мал нь худгаа сахиад зогсож байдаг байлаа.

Харин энэ шинэ шахуурга дуу чимээ багатайгаас гадна ганц кноп дараад л усаа гаргах боломжийг бүрдүүлж өгсөн нь бидний ажлыг ихээхэн хөнгөвчилсөн.

Малчид бидний амьдрал ахуйг сайжруулахад чиглэсэн санал санаачилга гарган хэрэгжүүлсэн ‘Тийсс Хишиг Арвин ЖейВи’ компанийн хамт олонд талархал илэрхийлье” гэв.

“Тийсс Хишиг Арвин ЖейВи” компани нь төсөл хэрэгжүүлэх явцдаа орон нутгийн иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, тэднийг сургах, орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтран ажиллах замаар бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг төдийгүй тэдний хүртэх урт хугацааны үр өгөөжийг бий болгоход анхаардаг.

Австрали улсын уул уурхайн гэрээт олборлогч “Тийсс” компани нь үндэсний оператор “Хишиг Арвин Индустриал” компанитай хамтран Өмнөговь аймгийн Оюу Толгой зэс, алтны уурхайд, Монгол улсад анхны гэж тооцогдох налуу ам байгуулах төслийг 2016 оноос амжилттай хэрэгжүүлж байна.



АМЬЖИРГААНЫ ТҮВШИН ДООГУУР ЗАРИМ АЙЛ ӨРХӨД ТИЙСС КОМПАНИ БАЯР ХӨӨР БЭЛЭГЛЭЛЭЭ

Таван Толгой уурхайн ойролцоо амьдардаг, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур түвшний айл, өрхийн 200 гаруй хүүхдэд Монгол дах Тийссийн баг хамт олон шинэ жилийн баярын үеэр бэлэг өгч, баярлууллаа.

Дэд бүтцийн хөгжил сул, өрхийн санхүүгийн дарамт, хүндрэлийн улмаас сургууль, номын санд очих боломжгүй орон нутгийн хүүхдүүдэд зориулсан бэлгэнд ном, бичгийн хэрэгсэл болон оюуныг хөгжүүлэх тоглоомууд багтсан юм.

КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорио, уурхайн үйл ажиллагаа зогсох зэргээс үүдэн эдийн засаг хямарч, иргэд ажилгүй болох нөхцөл байдал үргэлжилж байгаатай холбогдуулан Тийсс компани эдгээр сумдын зарим иргэдэд 2021 оны 10 сараас эхлэн хоёр долоо хоногт нэг удаа витамин болон нэмэлт хүнсний бүтээгдэхүүний багц хүргэдэг дархлаажуулалтын хөтөлбөрийг эхлүүлж, тусламж үзүүлж байгаа билээ. Өмнөговь аймгийн Цогтцэций суманд бусад аймаг, сумдаас ирсэн бөгөөд орон нутгийн харьяалалгүй буюу төрөөс хэрэгжүүлж буй тусламж, үйлчилгээ, хүнсний хөтөлбөрт хамрагдаж чадаагүй олон айл өрх байдаг.

Тийсс компанийн мэдээлэл харилцааны ажилтан Венера хэлэхдээ: “Хүүхдүүд тэр бүр авч чаддаггүй ном, бичгийн хэрэгсэл зэрэг боловсролыг нь дэмжих зүйлс бэлэглэхийг бид зорьсон. Хүүхдүүд бэлэг аваад баяр хөөртэй байгааг харах сайхан байсан. Сумдад очсоноор бид хөдөө орон нутагт зарим айл өрхийн амьжиргааны нөхцөл ямар хүнд байгааг болон Орон нутагт дархлаажуулалтыг дэмжихэд чиглэсэн Тийссийн хөтөлбөр хэрхэн үр өгөөжөө өгч байгааг нүдээр харах боломж олдсон” гэв.

Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн хэрэгцээг ойлгож, дэмжлэг үзүүлэх нь урт хугацааны үр өгөөжийг бий болгохыг зорин ажиллаж байгаа Тийсс компанийн хувьд их чухал юм.

ТИЙСС КОМПАНИ МОНГОЛ УЛС ДАХ ДОХИОНЫ ХЭЛНИЙ ХЭЛМЭРЧ, ОРЧУУЛАГЧДЫН ХОЛБООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА.

Тийсс компани нь сонсголын бэрхшээлтэй ажилтнууддаа дэмжлэг үзүүлэх, оролцоог хангасан ажлын орчныг бүрдүүлж өгөх зорилгоор Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбоотой хамтран ажиллаж байна. Ажилд сонгон шалгаруулж авах, чиглүүлэх сургалт хийх, ажилтнуудынхаа өдөр тутмын амьдрал ахуйд эерэг нөлөө үзүүлэх, чадавхжуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Дохионы хэлний хэлмэрчидтэй хамтран ажилладаг.

Тийссийн ажилтан Э.Хулан түүнийг ажилд сонгон шалгаруулан авах явцад дохионы хэлний хэлмэрч цуг байлцсан явдалд талархаж байгаагаа илэрхийлсэн юм.

Тэрээр хэлэхдээ “дохионы хэлний хэлмэрчээр дамжуулан харьцахад амар байсан. Ярилцлагын явцад асуусан асуултууд тодорхой, ойлгоход хялбар байсан төдийгүй ажилд орох сонгон шалгаруулалтын үйл явц бэрхшээлгүй, найрсаг байсан. Тийсс компанид ажиллаж, ажлын хамт олон маань тусалж дэмжиж ажилладаг нь талархууштай байдаг. Дохионы хэлээр дамжуулан харилцдаг багийн гишүүдтэй хамт ажиллах нь ганцаараа мэт сэтгэгдэл төрүүлэхгүй сайхан байдаг” гэв.

Тийсс компани нь Олон талт байдал, оролцоог хангах чиглэлээр “Хүн бүр үнэ цэнэтэй” алсын хараа хэрэгжүүлдэг.

Бизнесийн хүрээнд бид нэг нэгнийгээ хүндэтгэдэг, үнэлдэг, анхаарал тавьдаг ажлын орчныг бүрдүүлэхийг зорин ажилладаг бөгөөд энэ нь ажилтанд аюулгүй гэдгээ мэдэрч, өөртөө итгэлтэй байх, тэдний санал, бодлыг сонсдог орчинд ажиллахаар өдөр бүр зорин ирэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

AmCham Members in 2022

ALTAI HOLDING LLC
АНДЕРСОН & АНДЕРСОН ХХК ANDERSON & ANDERSON LLP
ARD INSURANCE COMPANY
badrakh energy
Barloworld Mongolia CAT
Bloomberg TV Mongolia
CROWN RELOCATIONS
Cummins Mongolia
DB&GTS
Deloitte.
ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ
ERD
EY Building a better working world
GEM INTERNATIONAL
GOBI MONGOLIAN CASHMERE
GOLOMT BANK Committed to and Investing in Excellence
Golomt Capital Delivering diversity
GUND INVESTMENT
HERBALIFE NUTRITION
hi-pay
HUNNU RESOURCES
INTERNATIONAL SCHOOL OF ULAANBAATAR
Investcore
KHALIUN TUGUL
KHAN BANK
MACU
MT GROUP
ML MAHONEYLIOTTA
MANDAL insurance
MCS holding LLC
M&E MELVILLE ERDENEDALAI
METRO EXPRESS
МИК MIK HOLDING
MinterEllison
MONPOLYMET GROUP
MSM
NANO INTERNATIONAL
NARAN MANDAL
OBORTECH
ORIFLAME SWEDEN
Oyu Tolgoi
PAI MATRIX
PETROMATAD
PHILIP MORRIS
pwc
REDPATH
RioTinto
SANDVIK
SERUUN GROUP
Shangri-La hotel ULAANBAATAR
SKYtel
САУГОБИ СЭНДС SouthGobi Sands
StarChase
STATE BANK
STEPPE GROUP
TANAN EXPRESS TRADE LLC
TERRA EXPLORERS Oil & Gas MONGOLIA
THE BLUE SKY Hotel and Tower
THIESS
TDB TRADE & DEVELOPMENT BANK
TRAFIGURA
TransBank
TRANSWEST MONGOLIA LLC
TURKISH AIRLINES
TUSHIG GROUP
United Machinery, Inc.
VISA
woodmont International
XACBANK